Батлав.

Зөвшөөрч хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“Промикс Индастриал” ХХК-ий захирал Х.Мөнгөнсувд

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ДҮГЭЭР ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА “ХИМИЙН БОДИС ИМПОРТЛОХ, ХАДГАЛАХ, ХУДАЛДААЛАХ, АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

РЕГИСТРИЙН ДУГААР: 6523293

Хянасан:

Нийслэлийн ХБОБНХ-ын

Мэргэжилтэн: .........................

Биелэлтийг тайлагнасан:

“Промикс Индастриал” ХХК-ий инженер: Н.Алтанзул

2022 он

Гарчиг


1. Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл 3
2. Тухайн жилийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн товч танилцуулга 3
3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 5
4. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт 7
5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 7
6. Хог,хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт 8
7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт 9
8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт 10
9. Тухайн жилийн байгал орчины менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт 10
10. Хавсралт материал 11

1. **Төсөл хэрэгжүүлэгчийн товч мэдээлэл**

| | |
|---|---|
| Төслийн нэр: | Химийн бодис импортлох, хадгалах, ашиглах |
| Төсөл хэрэгжүүлэгч: | “Промикс индастриал” ХХК<br>Регистрийн дугаар: 6523293<br>Бүртгэлийн дугаар 9011614730 |
| Төслийн байршил: | Хан -Уул дүүрэг, 21-р хороо, Морин уулын 8-2 гудамж, Монгол улс, Улаанбаатар хот |
| Холбоо барих: | Утас: 99072696<br>Майл хаяг: Promix.industr@gmail.com |

2. **Тухайн жилийн бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлийн товч танилцуулга**

2.1. Компани 2022 оны БОМТ- г хэрэгжүүлэхэд нийт 8668.3 мянган төгрөг төсөвлөсөн бөгөөд түүний 58.5 хувийг сөрөг нөлөөг бууруулахад зориулахаар төлөвлөн ажилласан.

2.2. Манай байгууллага 2022 оны БОМТ-ний дагуу 8966.55 мянган төгрөгний зардал зарцуулан биелэлтийг хангаж ажилласан бөгөөд төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт1. Компаний 2022 оны БОМТ-г хэрэгжүүлсэн биелэлт, түүний нийт зардал

| Д/д | БОМ төлөвлөгөө | | Төлөвлөгөө биелэлт | |
|---|---|---|---|---|
| | Бүрэлдэхүүн хэсгүүд | Зардал мян. төг | Гүйцэтгэл | Зардал мян. төг |
| 1 | Хөрс усанд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах | 180.00 | Хан-Уул дүүргийн ТҮК-тэй гэрээгээр хог ачуулах зардал | 170.00 |
| | | | Хөрс шинжилгээний зардалд | 70.00 |
| 2 | Хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах | 400.00 | Хог хаягдалыг ангилан ялгах сав байршуулсан | 200.00 |
| 3 | Хүний эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг бууруулах | 4,490.00 | Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан | 310.00 |
| | | | Ажиллагсдыг химийн бодистой харьцах хөдөлмөр хамгааллын талаарх Монголын хими ч химийн инженер технологичийн холбооны сургалтанд хамруулсан | 200.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Ур чадвар дээшлүүлэх шаардлага гэж үзсэн хоёр ажилтанг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулсан | 880.00 |
| | | | Агуулахын ойр орчныг бүрэн камержуулсан | 3,024.50 |
| | | | Үйлдвэрийн гадна талбайд тамхи татах цэг байгуулсан | 900.00 |
| 4 | Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд | 1,703.30 | Газар бэлтгэх, зүлэгжүүлэлт | 800.00 |
| | | | Моджуулалт шар хуайс 100 үрсэлгээ суулгасан | 400.00 |
| 5 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 1,360.00 | Үйлдвэрийн сав баглаа боодлын хог ангилан тустай ялгаж хадгалах агуулах сав барьсан | 500.00 |
| | | | Химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдлыг мэргэжлийн компанитай гэрээ байгуулан зайлуулж байна | 1,050.00 |
| 7 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 345.00 | Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх | 150.00 |
| | | | Агаарын тоосны хийлгэх | 200.00 |
| | | | Хөрс, усны шинжилгээ | 130.00 |
| 8 | БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | - | Гүйцэтгэх захирлын ... тоот тушаалаар Чанар хяналтын инженер Н.Алтанзулыг БОМТ-ний гүйцэтгэл хангахтай холбоотой зохицуулалт хийх ажилд томилон гүйцэтгүүлсэн. | |
| | **Нийт** | **8668,3** | | **8,984.50** |

## 2.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүрээлэн буй орчны хөрс усанд нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| 2.1. Хөрс, усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт | | | | |
| 1 | Ахуйн хог хаягдлаас болон автомашинаас үүдэлтэй хөрсний бохирдол | Ахуйн хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулж байх | Агуулах орчимд | Хан-Уул дүүргийн ТҮК-тэй гэрээ байгуулж сар бүр тогтмол хог зайлуулж байна. /Хавсралт 1/ |
| | | Агуулахын орчны хөрсний шинжилгээг хийлгэх | | Хөрсний шинжилгээг төлөвлөгөөний дагуу хийлгэсэн бөгөөд шинжилгээний дүнгээр хөрсний бохирдол үүсээгүй дүгнэлт гарсан. /Хавсралт 1/ |
| 2.2. Хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах талаар | | | | |
| 2 | Ахуйн болон химийн бодисын сав баглаа боодлыг ил задгай хаяснаас агуулахын орчин бохирдож болзошгүй | Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх | Агуулах орчимд | Ангилан ялгах саванд ангилан ялгаж хаяж хэвшиж байна. баталгаажих зураг хавсаргав. |
| | | Хог хаягдлыг ангилан ялгах савтай болох | | Төлөвлөгөөний дагуу ангилан ялгах сав хийж үйлдвэрийн хашаанд байрлуулсан /Хавсралт 1/ |
| 2.3. Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах | | | | |
| 3 | Ажиллагсдыг эмнэлгийн үзлэгт хамруулах | | Ажиллагсад | Гүйцэтгэх захирлын тушаалаар нийт ажиллагсдыг нэг өдрийн цалинтай чөлөө олгон эрт илрүүлэг шинжилгээнд хамрагдуулсан бөгөөд илүү дэлгэрэнгүй шинжилгээ өгөх шаардлагай зарим ажилтаныг Сонгодоо эмнэлэгт шинжилгээнд хамруулсан. /Хавсралт 2/ |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Ажиллагсдыг химийн бодистой харьцах хөдөлмөр хамгааллын талаарх сургалтыг мэргэжлийн байгууллагаар жилд 1 удаа зохион байгуулах | | Монголын химич, химийн инженер технологичдын холбооны байгууллагаар нийт ажиллагсдад химийн бодистой харьцах хөдөлмөр хамгаалалын суртгалт зохион байгуулсан. /Хавсралт 2/ |
| 5 | Агуулах болон бусад ажлын байранд мэргэжлийн бөгөөд ур чадвараараа тэнцсэн ажилтанг ажиллуулах | | Ур чадвар дээшлүүлэх шаардлага гэж үзсэн хоёр ажилтанг мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулсан:<br>1. Үйлдвэрийн дарга Батболдыг /МБМҮХолбооноос хийсэн лаборант, операторын сургалтанд хамруулсан<br>2. ХАБЭА-н ажилтан бэлтгэх сургалтанд ажилтан Идэрхишиг хамрагдсан<br>/Хавсралт 2/ |
| 6 | Төслийн талбай болон агуулахын орчныг камержуулах арга хэмжээ авна | Агуулах орчимд | Агуулахын ойр орчныг бүрэн харуулсан камержуулалт дохиоллын систем байршуулсан. /Хавсралт 2/ |
| 7 | Тамхи татах цэг байгуулах | Ажиллагсад | Үйлдвэрийн гадна талбайд тамхи татах цэг байгуулсан /Хавсралт 2/ |

1. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

| № | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Арга хэмжээний хамрах хүрээ | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| 1 | Ногоон бүс үүсгэх талбайг чөлөөлж цэвэрлэх | Газар бэлтгэх | Зурвас газар | Хавар 5-р сард үйлдвэрийн байрны орчинд зүлэгжүүлэлт хийж шар хуайс тарьсан /Хавсралт 3/-р баталгаажих зураг хавсаргав |
| 2 | Хайлаас, шар хуайс тарьц суулгаж арчилна | Моджуулах | Ногоон бүсэд | |
| 3 | Гадна талбайн гэрэлтүүлэг | | Обьектын орчинд | Үйлдвэрийн байрны гадна талбайд гэрэлтүүрэг хийсэн. |

2. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн талбайн бүс нутагт хамгаалалтанд авах шаардлагатай түүх соёлын өв байршаагүй тул энэ чиглэлд арга хэмжээ төлөвлөх шаардлагагүйг БОННҮ-нд тодорхой тусгасан.

3. Хог,хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө | урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний хамрах хүрээ | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| 1 | Ахуйн хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох, шингэн хог хаягдлаар хөрс, газар доорх ус, бохирдож болзошгүй. Химийн бодисын сав баглаа боодлыг ил задгай хаяснаар орчин бохирдох | Ажилчдын 00-д ариутгал халдваргүйжүүлэлт хийнэ | Ариун цэврийн -д | Зуны улиралд олон 7 хоног тутам халдваргүйжүүлэлт ариутгал хийж байсан /Хавсралт 3/ баталгаажуулав |
| 2 | | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь 3 төрлөөр ангилж түр хадгалах савнууд байршуулна | Хог хаягдлын нэгдсэн цэгт | Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах сав байршуулсан бөгөөд /Хавсралт 1/ |
| 3 | | Ахуйн ангилсан хог хаягдлын1 цэгийг тусдаа байгуулна | Ажлын байрны орчинд | Үйлдвэрийн хог хаягдал, ахуйн хог хаягдал, 2-г тусд нь цаг байгуулсан. /Хавсралт 1 |
| 4 | | Хог хаягдлыг тээвэрлэж зайлуулж байх | Төслийн хүрээнд | Гэрээний дагуу хог хаягдлуудыг зайлуулж ажиллаж байна |
| 5 | | Химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдлыг мэргэжлийн компанитай гэрээ байгуулан зайлуулах | Үйл ажиллагааны хүрээнд | Үйлдвэрийн хог хаягдал болох химийн бодисын сав баглаа боодлыг тусгай хадгалах цэгт байршуулан устгал хийдэг гэрээт байгууллагатай гэрээлэн устгалд оруулж байна. /Хавсралт 1/ |

4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Хяналт шинжилгээ хийх байршил | Хугацаа ба давтамж | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| 6.1 Агаарын чанар | | | | |
| 1 | Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх | Төсөлд хэрэгжих талбайд хяналтын 1 цэг сонгох | Жилд 1 удаа | Агаарын бохирсл, тоосжилт, орчны дуу шуугиан чичиргээний хэмжилт хийдэг мэргэжлийн байгууллагаар Үйлдвэрийн байрны орчинд хяналт шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний дүгнэлт /Хавсралт 4/ |
| 2 | Агаарын тоосны хийлгэх | | Жилд 1 удаа | |
| 3 | Дуу шуугиан чичиргээ | | Жилд 1 удаа | |
| 6.2 Усны хяналт шинжилгээ | | | | |
| 4 | Усны ерөнхий шинжилгээ | Унд ахуйн уснаас | Жилд 1 удаа | Унд ахуйн усанаас дээж авч Геологийн төв лабораторид шижилгээнд хамруулсан /Хавсралт 4 / |
| 6.3 Хөрсний бохирдол | | | | |
| 5 | Хөрсний хими физик шинж чанар, хүнд металлын шинжилгээг хийлгэх | Төсөлд хэрэгжих талбайд хяналтын 1 цэг сонгох | Жилд 1 удаа | Геологийн төв лабораторийн зааварчилгаагаар төслийн талбайн хяналтын 1 цэгээс хөрсний дээж авч шижилгээнд хамруулсан /Хавсралт 4/ |

5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Хэрэгжүүлэх хуваарь | | | | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|
| | | I улирал | II улирал | III улирал | IV улирал | |
| 1 | БОМТ-ний гүйцэтгэлийг хангахтай холбоотой зохицуулалт хийх | * | | | | Гүйцэтгэх захирлын ... тоот тушаалаар Чанар хяналтын инженер Н.Алтанзулыг БОМТ-ний гүйцэтгэл хангахтай холбоотой зохицуулалт хийх ажилд томилон гүйцэтгүүлсэн. |
| 2 | БОХАБ-ын асуудлыг мэргэжилтэнд хариуцуулан үүрэгжүүлэх | * | | | | |
| 3 | Биелэлтэд үе шаттай хяналт тавьж ажиллах | * | * | * | | Биелэлтэд сар бүр Гүйцэтгэх захирал Х.Мөнгөнсувд хяналт тавьж ирсэн |

6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

| № | БОМТ-г тайлагнах оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Хугацаа | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хан-Уул дүүргийн 21 хорооны оршин суугчид | Илтгэл тавьж тайлагнах | Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл | 10 сарын 1 дүгээр 7 хоногт | |
| 2 | 21 дүгээр хорооны Засаг Даргын тамгын Газар | Гүйцэтгэлийн мэдээллийг хэвлэмэл хэлбэрээр хүргүүлэх | Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл | 10 сарын 3 дугаар 7 хоногт | |
| 3 | НБОГ -т тайлагнах | Гүйцэтгэлийн мэдээллийг хэвлэмэл хэлбэрээр хүргүүлэх | Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэл | 11 сарын 1 ны дотор | |

## ХАВСРАЛТ 1.

1. **Хан-Уул дүүргийн ТҮК-тэй байглсан хогны гэрээний /хуулбар/**
2. **Химийн бодисын сав баглаа боодлын хог хаягдлыг устгуулах гэрээний /хуулбар/**
3. **Гэрээний үүргийн дагуу 50м радиус дахь орчны цэвэрлэгээ хийсэн тухай баталгаажих зураг**
4. **Хөрсний шинжилгээний хариу /хуулбар/**
5. **Хог хаягдлыг ангилан ялгах савтай хийж үйлдвэрийн хашаанд байрлуулсан тухай баталгаажих зураг**

БАТЛАВ.
ХУД-ийн "ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ" ОНӨААТҮГ-ын ЗАХИРАЛ Ц.ЭРДЭНЭБААТАР

БАТЛАВ.
ПРОМИКС ИНДАСТРИАЛ ХХК
/Захиалагч ААН, байгууллага/
ЗАХИРАЛ Х. МӨНГӨНСУВД

# ХОГ ХАЯГДАЛ АЧИЖ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

**2021 оны 12 сарын 24** **№21-21/07** Улаанбаатар хот

## Нэг. Ерөнхий зүйл

1.1 Нэг талаас Хан-Уул дүүргийн "Тохижилт үйлчилгээний Төв" ОНӨААТҮГ /цаашид Гүйцэтгэгч гэх/, Нөгөө талаас **6523293** тоот регистрийн дугаартай, Хан-Уул дүүргийн **21**-р хорооны нутаг дэвсгэрт байрлах, **Барилгын матеариал худалдаа** чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг **ПРОМИКС ИНДАСТРИАЛ ХХК** /цаашид Захиалагч гэх/ нар доорхи нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2 Энэхүү гэрээ нь **2021 оны 12 сарын 24**-ны өдрөөс **2022 оны 12 сарын 23**-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

1.3 "Хог хаягдлын тухай" хуулийн хүрээнд ХУД-ийн нутаг дэвсгэрийн орон сууц, гэр хорооллын айл өрх, ААН байгууллага болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тээвэрлэх, мөн нийтийн эзэмшлийн зам талбайд үүссэн хог хаягдлыг тээвэрлэх, түүнтэй холбогдон гарсан төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

1.4 Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын **2013 оны 09-р сарын 26-ны өдрийн 12/45** дугаар тогтоолоор Хог тээврийн үйлчилгээний хураамжид НӨАТ /нэмэгдсэн өртгийн албан татвар/-ыг тооцоогүй болно.

1.5 Хан-Уул дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн **2013 оны 04-р сарын 18-ны өдрийн А/29** тоот тогтоолын дагуу гэрээний үнийн дүнг хоёр тал харилцан тохиролцон тогтоосон болно.

## Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

2.1 Гүйцэтгэгч нь захиалагчтай байгуулсан гэрээнд заасан хуваарийн дагуу ААН байгууллага, орон сууцны бункерийн хог хаягдлыг саадгүй ачиж тээвэрлэх үүрэгтэй.

2.2 Тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол графикт зааснаас бусад цагаар нэмэгдэл хүч зохион байгуулан ачуулах арга хэмжээг авна.

2.3 Айл өрхөөс гарч буй ахуйн хогийг тогтмол цагт цуглуулах, мөн барилга барих, буулгах, засварлах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжийн хог хаягдлын төлбөрийг төлүүлсний дараа тээвэрлэнэ.

2.4 Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, битүүмжилсэн зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх.

2.5 Гүйцэтгэгч нь ажил үйлчилгээ үзүүлсний төлбөрийг ААН, байгууллага болон иргэд, захиалагч байгууллагуудаас шаардах эрхтэй.

2.6 Захиалагч тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулаагүй тохиолдолд хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.

2.7 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

## Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

3.1 Захиалагч тал "Хог хаягдлын тухай /шинэчилсэн найруулга/" хуулийг мөрдөж ажиллана.

3.2 Тухайн ААН, байгууллага, барилга байгууламжаас гарсан хог хаягдлыг зөвхөн тогтоосон хогийн цэг буюу бункерт хийж ачуулах үүрэгтэй.

3.3 Тухайн ААН, байгууллага өөрийн талбай /хашаа/-аас гадагш **50 метрийн** зай дахь талбайн цэвэрлэгээг хариуцах үүрэгтэй. Цас орж, мөс тогтсон мөн бусад байдлаар бохирдсон тохиолдолд тухайн талбайн цэвэрлэгээг байнга хийж гарах хог хаягдлыг тээвэрлүүлж байна.

3.4 Захиалагч тал нь гэрээний 3.2-д заагдсан үүргийг биелүүлээгүй улмаас аливаа ААНБ, иргэнд учирсан хохирлыг Захиалагч тал бүрэн хариуцна.

3.5 Хог хаягдлын төлбөрийг сар бүрийн 25-нд Хан-Уул Дүүргийн **Татварын Хэлтэс** болон **i-tax.mta.mn** сайтаас код авч тушаана.

3.6 ААН, байгууллагын барилга байгууламжид засвар хийсэнтэй холбогдон гарсан барилгын болон бусад хог хаягдлыг тухай бүрд нь дуудлага өгч буюу захиалгаар тээвэрлүүлэх үүрэг хүлээх бөгөөд хогны хэмжээнээс хамааран нэмэлт төлбөр төлж хариуцсан албан тушаалтантай хамтарч ажиллана.

3.7 Хог агуулах зориулалтын савыг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх бөгөөд хог ачихад саад учруулахгүй газар байрлуулж, машин чөлөөтэй орж гарах нөхцөлийг хангана.

3.8 Хогийн сав, бункерийн орчимд машин тэрэг тавиулсны улмаас хог ачих боломжгүй болж хог тээвэрлэх автомашин буцах, хугацаа алдсан тохиолдолд холбогдон гарах хариуцлагыг Захиалагч хүлээнэ.

3.9 Өөрийн эзэмшил, өмчлөлийн барилгаа барих, буулгах, засварлах тохиолдолд гарах хог хаягдлыг хаях талаар гүйцэтгэгч талтай урьдчилан гэрээ байгуулан зохих төлбөрийг төлнө.

3.10 Хог хаягдал гаргасны төлбөрийг хугацаанд нь бүрэн төлөх үүрэгтэй.

3.11 Зориулалтын цэгээс бусад газарт хог хаягдал хаяхгүй байх.

3.12 Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдлэгийг ажилтандаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах.

3.13 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага орчны газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх болон хог хаягдлыг зайлуулах олон нийтийг хамарсан ажилд оролцох үүрэгтэй.

3.14 Гүйцэтгэгчээс ажил үүргээ тогтоосон хугацаанд гүйцэтгэхийг шаардах эрхтэй.

3.15 Дүүрэг болон бусад байгууллага, албан тушаалтнаас зарласан уралдаан, аянд идэвхитэй оролцож тодорхой үр дүн үзүүлсэн бол шагнал урамшуулал хүртэх эрхтэй.

3.16 Гүйцэтгэгч ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд төлбөр төлөхгүй байх эрхтэй.

3.17 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүргийг эдэлнэ.

## Дөрөв. Төлбөр тооцоо, үнэлгээ

4.1 Гэрээт хугацаанд **Рейс захиалгаар** иргэн, ААНБ-ийн бункерийн хог, хаягдлыг ачиж тээвэрлэнэ.

4.2 Хог тээвэрлэсний төлбөр нь ХУД-ийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон тарифын дагуу харилцан адилгүй байх бөгөөд тухайн байгууллагын хог тээвэрлэлтийн төлбөр дээрх тогтоолд заасны дагуу сард улиралд ...................... жилд .................... төгрөг байна.

4.3 Тухайн байгууллагын хог тээвэрлэлтийн төлбөр дээрх тогтоолд заасны дагуу Орон сууц, ААН, хувь хүний захиалгаар хог тээвэрлэлт хийхэд гарах төлбөр:

| | | |
|---|---|---|
| 8 тн шахдаг автомашин | - Ахуйн хог хаягдал | - 150,000.00 төгрөг |
| 4 тн шахдаг авто машин | - Ахуйн хог хаягдал | - 85,000.00 төгрөг |
| 4 тн задгай тэвштэй автомашин | - Ахуйн хог хаягдал | - 85,000.00 төгрөг |
| 4 тн задгай тэвштэй автомашин | - Барилгын хог хаягдал | - 95,000.00 төгрөг |

4.4 "Хог хаягдлын тухай" хууль, бусад эрх зүйн актын өөрчлөлт болон зах зээлийн үнийн интервалаас хамаарч үйлчилгээний үнийн тарифт өөрчлөлт оруулж болно.

4.5 Хог тээвэрлэлтийн тарифт өөрчлөлт орсон тохиолдолд талуудын төлөөлөл тохиролцон гэрээнд нэмэлт оруулж мөрдөнө. Хэрэв хатуу хог хаягдал болон барилгын засвараас гарсан чулуу, мод, шорооны хог хаягдлыг тээвэрлүүлэх тохиолдолд нэмэлт тарифыг мөрдөх бөгөөд төлбөрийг төлсний дараа гүйцэтгэгч тээвэрлэнэ.

4.6 Үйл ажиллагааны онцлогоос хамаарсан хог хаягдлын тээвэрлэлтийг өвөл, зуны батлагдсан графикийн дагуу төлбөр төлөгдсөний дараа тээвэрлэнэ.

4.7 Хог тээвэрлэлтийн төлбөрийг ААН, албан байгууллага, үйлчилгээний газрууд нь гэрээний 3.3-д заасан хугацаанд бүрэн төлж барагдуулна. Төлбөрийг хожимдуулсан тохиолдолд хоног тутам 0,5%-ийн алданги төлнө.

## Тав. Хамтран хүлээх хариуцлага

5.1 Талууд энэхүү гэрээ зөрчигдөөгүй тохиолдолд дангаараа гэрээг цуцлах эрхгүй.

5.2 Талууд аливаа маргаан, үл ойлголцлыг харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд шаардлагатай бол холбогдох хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

5.3 Нийслэл дүүргээс зохион байгуулах их цэвэрлэгээний ажилд дайчлагдан ажиллах үед хог ачилтын хуваарь 1 өдрөөр хойш шилжих асуудал гарч болно. Үүнийг тухайн ААН, байгууллагад урьдчилан мэдэгдэх бөгөөд төлбөр төлөлтөнд ямар нэгэн өөрчлөлт орохгүй.

## Зургаа. Торгуулиас чөлөөлөгдөх нөхцөл

6.1 Байгаль, цаг уурын онц ноцтой үзэгдэл тохиолдох, хүндэтгэх шалтгаанаар авто зам хаагдсаны улмаас хог ачих боломжгүй болсон.

6.2 Удирдах, дээд байгууллагын шийдвэрээр автомашиныг өөр ажилд дайчилсан тохиолдолд энэхүү гэрээний 5.2 дахь заалт хамаарахгүй.

## Долоо. Бусад

7.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

7.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

## Найм. Нэмэлт өөрчлөлт

20 ..... оны ..... сарын ..... –ний өдөр талууд харилцан тохиролцож энэхүү гэрээнд дараах нэмэлт өөрчлөлтийг оруулав.

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

.......................................................................................................................................

Ес. Гэрээний сунгалт

9.1 Гэрээний хугацаа дуусаж, талууд гэрээг цуцлах талаар албан бичгээр санал гаргаагүй бол гэрээг анх байгуулагдсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

9.1.1 Энэхүү гэрээг 20 ..... оны ..... сарын ..... өдрөөс 20 ..... оны ..... сарын ..... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: ______________________________

Гэрээ сунгасан: ______________________________

Тайлбар: ______________________________

______________________________

______________________________

9.1.2 Энэхүү гэрээг 20 ..... оны ..... сарын ..... өдрөөс 20 ..... оны ..... сарын ..... өдөр хүртэл талууд харилцан тохиролцож сунгалт хийсэн болно.

Гэрээ сунгасан: ______________________________

Гэрээ сунгасан: ______________________________

Тайлбар: ______________________________

______________________________

______________________________

Арав. Гэрээ байгуулсан талууд

Гүйцэтгэгч тал:

ХУД-ийн "Тохижилт Үйлчилгээний Төв" ОНӨААТҮГ:

Гэрээ байгуулсан:

Хороо хариуцсан хяналтын алба ажилтан

........................................./Б.Энхжаргал/

Утас: 80151510, 88711247 95071965

Хог тээвэрлэлтийн захиалга өгөх, санал гомдлын утас: 77111965, 80771965, 95071965

Захиалагч тал:

Промикс индастриал ХХК

Захирал

Албан тушаалтай

........................................ /Х. Мөнгөнсувд /

Утас: 99072696

Хаяг: ХУД, 21-р хороо Морин Уул 8-2 гудамж 5 тоот

БАТЛАВ.
"ТҮМЭН ЭГШИГ" ХХК
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

................../Г.ЧИНЗОРИГ /

БАТЛАВ.
"Промикс индастриал " ХХК
ЗАХИРАЛ

................../ Х.МӨНГӨНСУВД/

# АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2022 оны 10 сарын 26-ний өдөр № 12/05-217 Улаанбаатар хот

Нэг талаас **Түмэн эгшиг ХХК** /цаашид "Хүлээн авагч" гэх/ төлөөлж Үйлдвэр хариуцсан дарга албан тушаалтай Б.Одбаяр, Нөгөө талаас **Промикс индастриал ХХК**-г /цаашид "Үүсгэгч" гэх/ төлөөлж албан тушаалтай Гүйцэтгэх захирал албан тушаалтай Х.Мөнгөнсувд бид харилцан тохиролцож Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль Засгийн газрын ***2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам", Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал*** болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

## Нэг. Гэрээний агуулга

1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.
1.2. Эл гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.
1.3. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.

## Хоёр. Аюултай хог хаягдалд тавигдах шаардлага

2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж "Аюултай хог хаягдал" гэсэн тэмдэглэгээтэй байна.
2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.
2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.
2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ ***БОАЖЯСайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг*** бүрдүүлж өгнө.
2.5. Аюултай хог хаягдлын *савыг суллаж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисны шинж чанарт тохирсон уусмалаар цэвэрлэсэн байна.* Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.
2.6. Хүлээн авагч тал Аюултай хог хаягдлыг "Аюултай хог хаягдал" тээвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий тээврийн хэрэгслээр ачиж тээвэрлэн шилжүүлэн авна.

## Гурав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх хугацаа, төлбөр төлөх нөхцөл

3.1. Гэрээний үргэлжлэх хугацаа нь 2022 оны .. сарын .. өдрөөс 2023 оны ... сарын .. өдрийг хүртэл 1 /нэг

3.2. Химийн хортой бодис хадгалсан хаягдал хуванцар сав дахин боловсруулах үйлчилгээний хөлс үнэ тариф, тээврийн зардал тооцсон болно. /НӨАТ тооцоогүй болно/

| № | Үйлчилгээний төрөл | Хэмжих нэгж | Тоо, хэмжээ | Нэгж үнэ /төг/ |
|---|---|---|---|---|
| 1 | Гялгар уут, шуудай, /25кг, 50кг, 1тн big bag шуудай/ | тн | 1 | 1250000 |
| 2 | Химийн бодисын хаягдал хуванцар, сав, канистр /0,5л, 1л, 2,5л, 5л, 10л, | тн | 1 | 1150000 |
| 3 | Химийн хуванцар торх /200л/ | ш | 1 | 7900 |

3.3. Эхний нийлүүлэлт нь гэрээ байгуулагдсанаас хойш 10 хоногийн дотор үүсгэгч нь хүлээн авагчид шилжүүлсэн байна.

3.4. Энэхүү гэрээний 1-р хавсралтад заасан Үүсгэгчээс гарах хаягдлын урьдчилсан төлөвлөгөөний дагуу аюултай хог хаягдалын хуримтлал үүссэн тохиолдолд үүссэн хаягдлын хэмжээнээс хамаарч 90-ээс 180 хоногт аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлсэн байна.

3.5. Үүсгэгч нь аюултай хог хаягдлаа шилжүүлэх тухай хүсэлтээ хүлээн авагчид албан бичгээр эсвэл chemicalwasterisk@gmail.com хаягаар 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэнэ. Хүлээн авагч тал үүсгэгчтэй харилцан тохиролцож аюултай хог хаягдлыг шилжүүлэх ажлыг товлоно.

3.6. Хүлээн авагч нь Үүсгэгчээс аюултай хог хаягдал шилжин ирэх товлосон өдөр, цагт аюултай хог хаягдлыг хүлээн авах хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

3.7. Аюултай хог хаягдлыг хүлээн авагч хүлээн авах үед үүсгэгчээс ирүүлсэн дагалдах бичигт дурдсан мэдээлэл зөрсөнөөс үүдэж гэрээний үнэ өөрчлөгдөж болно. Энэ тохиолдолд хог хаягдлыг хүлээн авах үед тооцож гаргасан үнээр бодож үүсгэгч хүлээн авагчид төлбөрийг төлнө.

3.8. Үүсгэгч нь гэрээний төлбөрийг аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэх тухай захиалга өгсөнөөс хойш ажлын 3 хоногийн дотор Түмэн эгшиг ХХК-ийн **Худалдаа хөгжлийн банк 499085408** тоот дансанд төлбөрийн нэхэмжлэхийн дагуу 100 хувь төлнө.

3.9. Хүлээн авагч нь тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр аюултай хог хаягдлыг тээвэрлэнэ. Хүлээн авагчийн тээврийн зардал гэрээний үнийн дүнд орсон болно.

## Дөрөв. Талуудын эрх, үүрэг

4.1 **Үүсгэгчийн эрх, үүрэг:**

4.1.1 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа гэрээнд заасан хугацааны дотор хүлээн авахыг хүлээн авагчаас шаардах эрхтэй.

4.1.2 Үүсгэгч нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүлээлгэн өгнө.

4.1.3 Үүсгэгч нь Аюултай хог хаягдлын дагалдах бичгийг 2 хувь үйлдэж, гарын үсэг тамга тэмдэг дарж өөртөө бичгийг буцаан авна.

4.1.4 Аюултай хог хаягдлыг хүлээн авагчид хүргэх тээврийн зардлыг хариуцна.

4.1.5 Үүсгэгч Аюултай хог хаягдлыг хүлээн авагчаар тээвэрлүүлэхээр бол тусад нь аюултай хог хаягдал тээвэрлэх гэрээ байгуулах харилцан тохиролцож шилжүүлнэ.

4.1.6 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг хүлээн авагчид хугацаанд нь төлнө.

4.1.7 Шилжүүлэх аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг хүлээн авагчид үнэн зөв мэдээлнэ. Худал, буруу ташаа мэдээлсэнээс бусдын эрүүл мэнд, амь нас, талуудын эд хөрөнгө болон байгаль орчинд хохирол учирвал үүнээс үүсэх хохирлыг үүсгэгч тал хариуцна.

4.1.8 Үүсгэсэн аюултай хог хаягдлаа хүлээн авагчид шилжүүлэх тухайгаа 5-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авагчид мэдэгдэнэ.

4.2 **Хүлээн авагчийн эрх, үүрэг**

4.2.1 Үүсгэгчээс Гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангасан аюултай хог хаягдлыг хүлээн авах

4.2.2 Үүсгэгчээс шилжүүлсэн аюултай хог хаягдал нь гэрээний 2.5-д заасан шаардлагыг хангаагүй, дагалдах бичигт үл зохицол үүссэн, тоо, хэмжээтэйгээ зөрж байвал уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзах эрхтэй.

4.2.3 Үүсгэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр аюултай хог, хаягдлыг гэрээнд заасан буюу товлосон хугацаанаас 30-аас дээш хоногоор хүлээн авагчид шилжүүлэлгүй хоцроовол хүлээн авагч тал гэрээг нэг талын санаачлагаар цуцлах эрхтэй.

4.2.4 Аюултай хог хаягдал хүлээн авсан төлбөр тооцоог үүсгэгчээс гэрээнд заасан хугацааны дотор төлөхийг шаардах эрхтэй.

4.2.5 Аюултай хог хаягдлыг хүлээж авсан актыг үүсгэгчид гаргаж өгнө.

4.2.6 Хүлээн авагч аюултай хог хаягдлыг хүлээн авсанаас хойшхи түүний хадгалалт, устгал, дахин боловсруулалтыг хариуцна.

4.2.7 Үүсгэгчээс Аюултай хог хаягдал шилжиж ирэх үед хариуцсан ажилтнаа бэлэн байлгаж, зохих журмын дагуу хаягдлыг хүлээн авна.

## Тав. Аюултай хог хаягдлыг шилжүүлэх, шилжүүлэн авах

5.1. Үүсгэгч гэрээнд заасан шилжүүлэх хугацаанаасаа өмнө аюултай хог хаягдлыг шилжүүлэх эрхтэй ба ингэх тохиолдолд Хүлээн авагчид энэ тухай 5-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдсэн байна.

5.2. Талууд аюултай хог хаягдлыг хүлээлцэхдээ дагалдах бичиг болон гэрээнд заасан тоо, хэмжээтэй нийцэж байгаа эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалгах ба нийцэж байвал энэ тухай акт үйлдэж гарын үсэг зурж хүлээн авагч тал хүлээн авна.

5.3. Аюултай хог хаягдал нь гэрээний 4.2.2-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд хүлээн авагч хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд Аюултай хог хаягдлыг үүсгэгчид буцааж хүргэхтэй холбогдон гарах зардлыг үүсгэгч тал хариуцна.

## Зургаа. Өмчлөх эрх шилжих

6.1. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл хог хаягдлын өмчлөгч байна.

6.2. Үүсгэгч нь хог хаягдлыг хүлээн авагчид ачиж, тээвэрлэн хүлээн авах цэг дээр хүлээлгэн өгснөөр өмчлөх эрх хүлээн авагчид шилжсэн гэж үзнэ.

6.3. Аюултай хог хаягдлыг хүлээн авах цэг дээр хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл түүний үр шим, эрсдэл үүсгэгчид байх ба хүлээн авагчид хүлээлгэн өгснөөр үр шим, эрсдэл хүлээн авагчид шилжинэ.

## Долоо. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

7.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.

7.2. Үүсгэгч энэ гэрээний 3.8-д заасны дагуу үнийг төлөх хугацааг хэтрүүлсэн бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн

дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Хүлээн авагчид төлнө.

7.3. Хэрэв Хүлээн авагч нь Үүсгэгчээс ирүүлсэн хог хаягдлыг энэ гэрээний 3.4-т заасан хугацааны дотор зохих журмын дагуу хүлээн аваагүй, хугацааг хожимдуулсан бол Талууд харилцан тохиролцож уг хугацааг сунгаснаас бусад тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хэтрүүлсэн хоног тутамд Үүсгэгчид төлнө.

7.4. Алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%-аас хэтрэхгүй байна.

7.5. Талууд гэрээнээс татгалзах болон цуцлах үндэслэлийг иргэний хуулиар зохицуулна.

7.6. Үүсгэгч тал аюултай хог хаягдлыг хүлээн авагчид шилжүүлэхдээ дагалдах бичиг болон гэрээний хавсралт 1-д заасан тоо хэмжээ, химийн бодисын нэр хаягийг үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд буруу, зөрүүтэй худал мэдээлснээс болж гэрээний үнийн дүн өөрчлөгдөх, эсвэл үүнээс үүдэж хохирол учирвал хүлээн авагч хариуцахгүй болно.

7.7. Энэ гэрээтэй холбогдон Талуудын хооронд үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг Талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй бол маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## Найм. Давагдашгүй хүчин зүйл

8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал гэдэгт үерт автах, гал түймэрт нэрвэгдэх, дэлбэрэлтэд өртөх, газар хөдлөх, зуд болох, тахал болон бусад байгалийн хүчин зүйлс мөн цэрэг дайны үйл ажиллагаа, төрийн эрх барих байгууллагын шийдвэр буюу экспорт, импортын хориг, ажил хаялт, үйлдвэрлэгчийн бүх төрлийн сул зогсолт зэрэг талуудын үйл ажиллагаанаас үл хамаарах үндэслэлээр энэхүү гэрээг зохих ёсоор биелүүлэх боломжгүй байдлыг бий болгохыг ойлгоно.

8.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээ биелэгдэх боломжгүй тохиолдолд талууд бие биедээ нэн даруй мэдэгдэх ба гэрээний хугацаа дээрх нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгагдах буюу тодорхой хугацаа зааж сунгаж болно.

8.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас бараа материал устсан, дутсан тохиолдолд шилжүүлэн хүлээлгэн өгөх хүртэлх эрсдэлийг үүсгэгч, шилжүүлэн хүлээн авснаас хойшхи эрсдлийг хүлээн авагч хариуцна.

8.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлыг зохиомлоор буюу болгоомжгүйгээр бий болгосноос бусад тохиолдолд форс мажорын нөхцлөөс шалтгаалан учирсан хохирлыг хариуцах үүргээс талууд чөлөөлөгдөнө.

## Ес. Бусад зүйл

9.1. Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд бичгээр үйлдэж эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.2. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах ба талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

9.3. Энэхүү гэрээг Монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, Үүсгэгч тал 1 хувь, Хүлээн авагч тал 1 хувийг тус тус хадгалсан нь хуулийн ижил хүчинтэй.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Үүсгэгч талыг төлөөлж:
ПРОМИКС ИНДАСРИАЛ ХХК -ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
................................................/Х.Мөнгөнсувд/

Суурин утас:

Гар утас: 99072696, 96660042

Регистер:6523293

УБ гэрчилгээний дугаар:

Химийн бодис ашиглах, импортлох тусгай зөвшөөрлийн дугаар:МҮ-1702722

Хаяг: ХУД, 21-р хороо Морин уул 8-2 гудамж тоот

Email хаяг: Promix.industr@gmail.com

Хүлээн авагч талыг төлөөлж:
ТҮМЭН ЭГШИГ ХХК-ийн
ЕРӨНХИЙ МЕНЕЖЭР

.................................../ Б.Одбаяр /

Суурин утас: 77110428

Гар утас: 92050001,88990428

Регистер: 5031923

УБ гэрчилгээний дугаар:

Тусгай зөвшөөрлийн дугаар: Б-000001

Хаяг: Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Намъянжугийн – 44 ,Түмэн эгшиг ХХК-ийн ,өөрийнбайр

Email хаяг:chemicalwasterisk@gmail.com

Шуудангийн хаяг:51 салбар 499 тоот



Зураг 1. Гэрээнд тусгагдсан ойр орчмын 50м радиус дахь орчны хог шороог тогтмол цэвэрлэсэн



Зураг 2. Орчны цэвэрлэгээ хийсэн байдал

CENTRAL GEOLOGICAL LABORATORY
When it comes to analyzing minerals in Mongolia

**ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ**
18080 ш/х-437, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг,
Үйлдвэрчний эвлэлийн гудамж, ГТЛ-ийн байр,
Утас: 976-7018 2904, 7018 2914; Факс: 976-7018 4212
Цахим хаяг: info@cengeolab.com; http://www.cengeolab.com

ilac-MRA

MNAS Accreditation system TL 002 MNS ISO/IEC 17025

# ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН

| | |
|---|---|
| Захиалгын дугаар | : ХФ 2022/1863 |
